



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 17 он 06
сарын 08 өдөр

Дугаар ЗГ-1/26

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилуулах
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Гэлэгпилийн Чулуунбаатарыг Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын албан тушаалд томилуулах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2017 оны 06 сарын 08 өдөр

Дугаар Е/04.

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЖАРГАЛТУЛГЫН ЭРДЭНЭБАТ ТАНАА

Зөвшилцөх саналын тухай

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар Гэлэгпилийн Чулуунбаатарыг томилуулах асуудлаар зөвшилцөх тухай 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн ЗГ-1/84 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналтай танилцлаа.

Энэхүү асуудлыг хууль тогтоомжийн дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэх нь зүйтэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ШАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ

000000042



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2017.06.08 № 05/4378
танай 2017.06.08 -ны № 202/958 -Т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Гэлэгпилийн Чулуунбаатарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй байна.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг баримтлан ажиллах нь зүйтэй болно.

Хүндэтгэсэн,

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Х.ХАШБААТАР

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын гишүүн хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорч, Засгийн газрын гишүүн орон гарсан тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно” гэж заасан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж тус тус заасныг үндэслэн Гэлэгпилийн Чулуунбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар томилуулах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр танилцуулж байна.

Гэлэгпилийн Чулуунбаатар нь 1957 онд Ховд аймгийн Дарви суманд төрж, 1981 онд Монгол Улсын Их Сургуулийн Философийн салбарыг философич, нийгэм судлалын багш мэргэжлээр төгссөн. 1987 онд Москвагийн Нийгмийн Ухааны академид нийгмийн философийн чиглэлээр, 1988 онд Москвагийн Их Сургуульд философийн багшийн чиглэлээр, 1994 онд Швед Улсад зөвлөх үйлчилгээний чиглэлээр тус тус мэргэжил дээшлүүлсэн. 1993 онд Москвагийн Оросын Удирдлагын академийн аспирантурт суралцаж, философийн доктор /PhD/-ын, 1999 онд философийн шинжлэх ухааны доктор/ScD/-ын зэрэг тус тус хамгаалсан.

Г.Чулуунбаатар нь 1981-1990 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны институтид эрдэм шинжилгээний ажилтан, 1993-1994 онд “Прогноз” төвд эрдэм шинжилгээний ажилтан, 1994-1996 онд Улсын Их Хурлын дэргэдэх Судалгааны төвд эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1996-2016 онд ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн захирал, 2001-2008 онд Улсын Их Хурлын Тамгын газарт УИХ-ын даргын ахлах зөвлөх, албаны дарга, 1998-2007 онд Соёл Урлагийн Их Сургуулийн Соёл урлагийн менежментийн тэнхимийн эрхлэгч, тэргүүлэх профессор, 2008-2012 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн захирлаар тус тус ажиллаж байгаад 2016 оноос ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

Г.Чулуунбаатарын шинжлэх ухааны салбарт ажиллаж хуримтлуулсан туршлага, удирдан зохион байгуулах чадвар, ажил хэрэгч чанар зэргийг харгалзан Засгийн газраас дэвшүүлж байгаа зорилтуудыг биелүүлэх, танхимын зарчмаар ажиллах чадвартай гэж үзэн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын албан тушаалд томилуулах саналтай байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ..

Улаанбаатар
хот

Засгийн газрын гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар Гэлэгпилийн Чулуунбаатарыг томилсугай.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

ТАНИЛЦУУЛГА

1. Гэлэгпилийн Чулуунбаатарыг Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын албан тушаалд томилуулахаар танилцуулж байна.

2. 1957 онд Ховд аймгийн Дарви суманд төрсөн.

3. 60 настай.

4. Эрэгтэй

5. Гэр бүлийн байдал: Эхнэрийн хамт амьдардаг.




6. Хэзээ, хаана, ямар сургууль дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол	1957 онд Ховд аймгийн 1 дүгээр сургуулийг, 1981 онд Монгол Улсын Их Сургуулийн Философийн салбарыг төгссөн. 1987 онд Москвагийн Нийгмийн Ухааны академид нийгмийн философийн чиглэлээр, 1988 онд Москвагийн Их Сургуульд философийн багшийн чиглэлээр, 1994 онд Швед Улсад зөвлөх үйлчилгээний чиглэлээр тус тус мэргэжил дээшлүүлсэн. Философич, нийгэм судлалын багш мэргэжилтэй. Философийн доктор/PhD/, Философийн шинжлэх ухааны доктор/ScD/, профессор зэрэгтэй. Академич цолтой. Орос, англи хэлний мэдлэгтэй.
---	---

7. Ажилласан байдал	1981-1990 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны институтид эрдэм шинжилгээний ажилтан, 1993-1994 онд "Прогноз" төвд эрдэм шинжилгээний ажилтан, 1994-1996 онд Улсын Их Хурлын дэргэдэх Судалгааны төвд эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1996-2016 онд ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн захирал, 2001-2008 онд Улсын Их Хурлын Тамгын газарт УИХ-ын даргын ахлах зөвлөх, албаны дарга, 1998-2007 онд Соёл Урлагийн Их Сургуулийн Соёл урлагийн менежментийн тэнхимийн эрхлэгч, тэргүүлэх профессор, 2008-2012 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн захирлаар тус тус ажиллаж байгаад 2016 оноос ШУА-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байна.
---------------------	---

8. Ажилласан хугацаа /жилээр/	Төрийн албанд 36 жил, үүнээс боловсрол, шинжлэх ухаан, судалгааны байгууллагад 29 жил.
-------------------------------	--

9. Тухайн албан тушаалд томилуулах үндэслэл:	Засгийн газраас дэвшүүлж байгаа зорилтуудыг биелүүлэх болон Танхимын зарчмаар ажиллах чадвар, удирдан зохион байгуулах болон ажил хэрэгч чанарыг тус тус харгалзсан болно.
--	--

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Ж.ЭРДЭНЭБАТ

2017 оны 6 дугаар сарын 8-ны өдөр